

“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр “Улаанбаатар хот, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж, 39-2 “Велокс” оффиссын 3 давхрын хурлын танхимд 11 цагт хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийснээр эхлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаар ТУЗ-ийн шийдвэрээр байгуулагдсан Тооллогын комиссын дарга Ц.Наран-Учрал мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бөгөөд хурлын дарга Н.Ерөөгэрэл мэдэгдэв.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт хувьцааны 87,23 хувь буюу 13 725 015 ширхэг хувьцаа эзэмшиж буй 40 хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн дүрмийн 7.4-д заасан шаардлагыг хангасан болохыг Тооллогын комиссын дарга Ц.Наран-Учрал мэдэгдэж Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. \Тогтоолыг хурлын материалд хавсаргав.\

Тус хуралд “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Д.Ганхуяг, Д.Дуламсүрэн, М.Зулзаа, О.Тунгалаг, Д.Энхтогтох нар оролцов.

Н.Ерөөгэрэл- Өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлыг баталж, хувьцаа эзэмшигчдэд хурлын зар, хэлэлцэх асуудлын талаар тодорхой танилцуулга, мэдээллийг хүргүүлэн ажилласан билээ.

Хэлэлцэх асуудлын өмнө компанийн 2018 оны үйл ажиллагааны талаар та бүхэндээ товч танилцуулга хийе гэж бодож байна.

\ Үйл ажиллагааны тайланг хурлын материалд хавсаргав.\

1.Хэлэлцсэн нь: Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн талаар

Танилцуулсан нь: Н.Ерөөгэрэл- ТУЗ-ийн дарга

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2018 оны зорилтуудын хэрэгжилтийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Хөвсгөл

алтан дуулга ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Компанийн 2017 оны газар тариалангийн үйл ажиллагаанд тавьсан зорилго нь талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, тариалалтын технологийг сайжруулах, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалан, 1 га-аас авах ургацийн хэмжээг нэмэгдүүлэх, тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлж ажиллах байв. Гүйцэтгэх удирдлага тавьсан зорилгоо хангахад чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч ажилласан байна. Өнгөрсөн онд 3946 га талбайд улаан буудай, 420 га-д тосны ургамал, 29 га-д арвай, 21 га-д овьёос, 27 га-д халтар арвай, 23 га-д вандуй, 2 га-д гурвалжин будаа тариалсан байна. Тариалсан талбайн ургац урьд жилүүдийг бодвол харьцангуй сайн байжээ. Нийт 5975 тн буудай (га-аас 15.1 цн), 55.1 тн овьёос, 1.8 тн гурвалжин будаа хурааж, тосны ургамал, вандуйн талбай цасанд дарагдаж хураах боломжгүй болсон байна.

Гурилын үйлдвэрийн хувьд үйлдвэрлэл, борлуулалтыг 3 дахин нэмэгдүүлэх, борлуулалт, маркетингийн системийг шинэчлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, ISO 9001 стандартыг нэвтрүүлэх зорилтууд тавьж, зорилтуудыг бүрэн хангаж ажиллажээ. Гурилын үйлдвэр өнгөрсөн онд нийт 8.7 мян тонн буудай тээрэмдэж, 7.0 мян тн гурил, 1.7 мян тн дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн байна. Үтрэмд 2018 оны ургацаас 12.1 мян тн буудай хүлээн авсан байна.

2018 онд компани дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-өөр батлуулав. Энэ бизнес төлөвлөгөөнд үндэслэн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг гарган ажилласан ба газар тариалан болон гурилын үйлдвэрлэл төлөвлөгөөгөө үндсэндээ хангаж, компанийн санхүүгийн үзүүлэлтүүд өмнөх оноос эрс сайжирсан байна.

2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 3.7 тэрбум төг-ийн хувьцаа нэмж гаргахаар шийдвэрлэснийг амжилттай хэрэгжүүлсэн байна. Хувьцаа гаргаж татан төвлөрүүлсэн хөрөнгө нь компанийн эргэлтийн хөрөнгийн дутагдлыг багасгаж, гурилын үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх, газар тариалангийн нэн тэргүүний хэрэгцээт тоног төхөөрөмжийг худалдан авах, санхүүгийн зардлыг бууруулахад ихээхэн ач холбогдолтой байсан гэж үзэж байна. Мөн компанийн хувьцааны арилжаа идэвхжин, үнэ нь өсч, МХБ-ийн 3-р самбараас 2-р самбарт дэвшин бүртгэгдэж, ТОП20 индексийг бүрдүүлэгч хувьцаа болсон үр дүнг авчирсан байна.

Иймд “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн гүйцэтгэх удирдлага 2018 онд тавьсан зорилтуудаа хангаж, санхүүгийн хүндрэлээс гарахын тулд өөрсдийн нөөц бололцоогоо сайн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

2. Хэлэлцсэн нь: Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Танилцуулсан нь: Н.Ерөөгэрэл- ТУЗ-ийн дарга

“Хөвсгөл алтан дуулга” ХК нь 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 4.4 сая ширхэг хувьцаа буюу нийт хувьцааныхаа 28 хувьтай тэнцэх хувьцааг нэмж гаргах замаар 3.7 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн шийдвэрээр тус компанийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсныг тооцон, хоёдогч зах зээлийн арилжааг 9 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлүүлсэн юм. Ингэснээр манай компани нийт 15,734,200 ширхэг энгийн хувьцаатай, нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 157,342,000 төгрөг болсон байна. Энэ асуудалтай холбоотойгоор компанийн дүрмийн зарим заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай болсон юм.

КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

Одоогийн заалт	Өөрчлөх заалт
4.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15,734,200 ширхэг энгийн хувьцаа байна. Үүнээс нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 11,328,600 ширхэг энгийн хувьцааг гаргасан болно.	4.1 Компанийн зарласан бөгөөд гаргасан хувьцаа нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15,734,200 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
4.2. Компани нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 11,328,600 ширхэг энгийн хувьцаатай, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 113,286,000 төгрөг болно.	4.2. Компани нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15,734,200 ширхэг энгийн хувьцаатай, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 157,342,000 төгрөг болно.

3.Хэлэлцсэн нь: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Танилцуулсан нь: Н.Ерөөгэрэл- ТУЗ-ийн дарга

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаа, санаачлагыг идэвхжүүлэх, аливаа асуудалд ажил хэрэг, бүтээлчээр хандах хандлагыг дээшлүүлж, хариуцлагыг нэмэгдүүлэх, зохион байгуулсан ажилд оролцсон оролцоо, ажлын үр дүнг үнэлж, урамшуулах зорилгоор Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, ХК-ийн дүрмийн 7.8.7, 7.44 дэх заалтын дагуу тэдэнд цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцоог харгалзан тодорхой нэмэгдэл олгож байхаар 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 04 тоот тогтоол гарган хэрэгжүүлж байгаа юм. Дээрх тогтоолоор:

ТУЗ-ийн гишүүдийн цалин, нэмэгдэл		Хэмжээ, холбогдох татвар шимтгэлийг суутгасан байдлаар
		/төг/
Сард олгох тогтмол цалин ба нэмэгдэл	Энгийн гишүүд	50,000
	Хараат бус гишүүд	70,000
	Хороодын даргын нэмэгдэл	30,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	30,000

Оролцоонд үндэслэсэн нэмэгдэл	Хувьцаа эзэмшигчдийн хура ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	50,000
-------------------------------	---	--------

байхаар тогтоосон юм.

2018 онд ТУЗ-ийн цалин, урамшуулал, нэмэгдэлд нийт 7,920,000 төгрөг зарцуулсан байна.

2019 оны хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан дээрх шийдвэрийг хэвээр үргэлжлүүлэн мөрдөх саналтай байна.

4. Ногдол ашгийн тухай

Н.Ерөөгэрэл- ТУЗ-ын хурлаас Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах тухай шийдвэр гаргасан. Энэ асуудлыг Компанийн тухай хуулийн дагуу ХЭХ-д танилцуулах ёстой юм.

“Хөвсгөл алтандуулга” ХК нь 2018 онд 315 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Мөн нийт хөрөнгө 29 хувь өсч, төлбөрийн чадварын үзүүлэлт 0.8-аас 1.2 болж сайжирсан байна. Иймд хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 120 төгрөг, нийт 1,888,104,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар ТУЗ-өөс шийдвэрлэсэн.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийг 2019 оны 4-р сарын 1-ний өдрөөр тасалбар болгон тодорхойлсон.

Ногдол ашгийг 2019 оны 05-р сарын 01-нээс эхлэн компанийн байранд мөнгөн хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн болно.

Одоо санал хэлэх, асуулт тавьж хариулт авах ажилдаа оръё. Та бүхэн ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирлаас асуух зүйлээ асууна уу?

Б.Батзул-Компанийн 2018 оны үйл ажиллагааны талаар танилцуулга хийлээ. Компанийн үйл ажиллагаа жигдэрч санхүүгийн хувьд боломжийн гарчээ. Тус компанийн хувьцааны 70 гаруй хувийг эзэмшиж байгаа Тэс трейд ХХК-тай ямар харилцаатай байдаг вэ? Санхүүгийн хувьд бүрэн тусгаарлагдсан уу?

Н.Ерөөгэрэл- Өнгөрсөн онд нэмж хувьцаа гаргасны дараа Тэстрейд ХХК-ийн эзэмшиж байсан хувьцааны тоонд өөрчлөлт орж, нийт хувьцааны 50,82 хувийг эзэмших болсон. Манай хоёр компани тус, тусдаа үйл ажиллагаа явуулдаг компани юм. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх гэх мэт асуудал гарвал хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэдэг.

Г.Гансүх- Бид бол жижиг хувьцаа эзэмшигчид. Тэр болгон компанийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж багатай. Компанийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэг ямар хүмүүс байдаг вэ? Тухайлбал 5-аас дээш хувийг эзэмшдэг Золзаяа гэдэг хүн өнөөдрийн хуралд ирсэн болов уу?

Н.Ерөөгэрэл- Компанийн 5-аас дээш хувийг эзэмшдэг нэг компани бий. Энэ нь Тэс трейд ХХК. С.Хүрэлбаатар, Ж.Жигжидсүрэн, М.Золзаяа гэсэн 3 хувьцаа эзэмшигч бий. Тэс трейд ХХК-ийг төлөөлж тус компанийг үүсгэн байгуулагч Д.Ганхуяг болон дээрх 3 хувьцаа эзэмшигч бүгд хүрэлцэн ирсэн байгаа. Томоохон хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг

Хөрөнгийн биржийн цахим хуудаст гаргадаг. Бид компанийхаа үйл ажиллагааг нээлттэй байлгадаг. Хуулийн дагуу ажилладаг болохлоор хувьцаа эзэмшигчид маань бидэнд итгэдэг гэж боддог. Хүссэн үедээ компанитай холбоотой асуудлаар ирж мэдээлэл авдаг.

А.Жавхлан- Хөвсгөл алтан дуулга ХК ТОП-20 компани дотроо хамгийн өндөр ногдол ашгийг тарааж байгаа гэж бодож байна. Бид гэр бүлээрээ тус компанийн хувьцааг худалдан авахыг сонирхож байгаа. Бидний хувьд тус компани ногдол ашгаа жил бүр тарааж байвал баяртай байх нь ойлгомжтой. Бизнес төлөвлөгөөндөө ногдол ашгаа жил бүр нэмэгдүүлэх, олгох талаар тусгасан байсан. Энэ төлөвлөгөөгөө цаашдаа хэрэгжүүлж явах уу?

Н.Ерөөгэрэл- Бид бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлж ажиллахын төлөө зорьж ажиллана. Төлөвлөгөө мөөн амжилттай хэрэгжээд явбал ногдол ашгаа жил бүр өгөхийг хичээнэ. Биднээс шалтгаалах олон зүйл байгаа ч байгаль цаг, уураас шалтгаалах зүйл бас бий.

А.Жавхлан-Тус компани 327 хувьцаа эзэмшигчтэй болсон байна. Хувьцаа эзэмшигчидтэйгээ хамтран хувьцааныхаа үнийг өсгөх талаар, хувьцааны арилжаан дээр маркетинг хийхээр төлөвлөж байгаа зүйл байна уу? Тус компаний хувьд анхнаасаа барьсан чиглэл, зорилгоо өөрчлөөгүй. Үйл ажиллагаа нь тогтмолжсон. Тариагаа тарьж өөрсдөө боловсруулж бүтээгдэхүүнээ хийж байгаа цөөхөн компанийн нэг. Маш онцлогтой компани гэж боддог.

Д.Дуламсүрэн-Гүйцэтгэх захирал\ Хувьцааны арилжаатай холбоотой маркетингийн зүйл хийхгүй байгаа ч өөрсдийн үйл ажиллагааны талаар сонин, хэвлэл, телевиз, радиогоор мэдээлдэг. Ярилцлага өгдөг. Өөрийн цахим хуудас, пайж хуудсаар хувьцаа эзэмшигчид болон иргэдэд тогтмол мэдээллийг хүргэн ажиллаж байгаа.

С.Мягмарсүрэн- Хөвсгөл алтан дуулга ХК нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг өсгөсөн шилдэг компани гэж боддог. Хөрөнгийн биржийн жагсаалтын 1-р ангилалд орох байх гэж итгэдэг. Компанийн удирдлагууд нь мундаг байна. Та нөхдөд баяр хүргэе.

Д.Мөнхтөр- Би өөрөө газар тариалангийн салбарт ажиллаж байсан. Газар тариаландаа дуртай хүн. Танай компани маш сайхан компани. Та бүхэн 2018 онд Улсын тэргүүний тариаланч хамт олон болсонд баяр хүргэе. Энэ онд атаршсан хөрс нэмж ашиглаж байгаа юу?

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлогын хүрээнд усалгаатай тариалан эрхлэх ажил хийгдэх үү? Хөрсний үржил шим ямар байгаа вэ? Га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд ямар зорилт тавьж байна вэ?

Д.Дуламсүрэн- Манай компани 7000 га талбайтай. 1940-өөд оноос ашиглаж байсан хуучин САА-н талбай юм. Атаршсан талбай байхгүй. Одоогийн эзэмшиж байгаа хөрсний хувьд дундаж хөрсөнд орно. Хөрсийг хараар нь байлгах бодлого баримталдаг. Тариалангийн талбай уснаас хол. Усралтын систем тавихын тулд их хөрөнгө оруулалт шаардагдана. Технологи барьж ажиллах, байгаль цаг уурын хүндрэл тохиолдохгүй бол арвин ургац авах бүрэн боломж бий. 4500 га талбайд тариалалт хийнэ. Нэг га-гаас авах ургацаа нэмэгдүүлэх

108

бодлого барьж ажиллана. Энэ жил бордоо идэвхжүүлэгчийг захиалсан. Хэрэглэж эхэлж байгаа.

Г.Гансүх- Цасанд дарагдсан ургацаа малын тэжээлд хэрэглэх боломж бий юу? Вандуй тариалахад хир ургаж байна вэ?

Д.Дуламсүрэн- Болно л доо. Гэхдээ бид намар тэжээл хийгээд уриншинд шилжүүлсэн. Вандуй тариалахад ургахын хувьд ургана. Бидний хувьд туршлага багатай байсан болохлоор технологийг сайн барьж ажиллаж чадаагүй юм.

Д.Мөнхтөр- Вандуйгаа дангаар нь тарьсан уу? Хольж тарьсан уу?

Д.Дуламсүрэн- Овьёстойгоо хамт тарьсан.

Г.Гансүх- Тэжээлийн зориулалтаар ашиглаж болдог юмуу? Гурвалжин будаа ямар ургаж байна вэ?

Д.Дуламсүрэн- Тэжээлийн вандуй, хүнсний вандуй хоёр өөр. Бид хүнсний вандуй тариалж үзсэн юм.

Н.Ерөөгэрэл- Сэлгээний зориулалтаар тарьж болох эсэхийг туршиж үзсэн юм.

Д.Дуламсүрэн- Гурвалжин будааг тариалахад сайн ургадаг юм байна лээ. Гэхдээ хяруунд амархан цохигддог юм байна.

Б.Батзул- Халтар арвай тариалах уу?

Д.Дуламсүрэн- Энэ жилийн хувьд халтар арвайг бага тарих байх. Үрийн олдоц муу байгаа.

Б.Батзул- Бүтээгдэхүүний борлуулалт хир байна вэ?

Н.Ерөөгэрэл- Харилцагчийн бааз сууриа хадгалвал борлуулалт гайгүй байгаа. Ямар ч байсан 7 сар хүртэл түүхий эдийн нөөц хүрэлцээтэй байгаа.

М.Шигшээ- Дуламсүрэн захирлын ярилцлагыг телевизээр сонсож, компанийн үйл ажиллагаатай танилцаж байсан. Тариалан сум байгаль цаг уурын хувьд сэрүүн бүсэд оршдог юм байна. Би өнгөрсөн 7 сард ОХУ-ын Красноярск хотод очсон. Байгаль цаг уурын хувьд манайтай адил юм билээ. Вандуйг тариатай хамт тариалсан нь маш сайн ургасан байсныг ажигласан. Энэ арга ажиллагааг судалж үзвэл ямар вэ гэсэн санааг хэлэх гэсэн юм. Нөгөө талаар танай компани хүлэмжийн аж ахуй эрхлэх үү? Халтар арвай тариалах уу?

Д.Дуламсүрэн- Өвлийн хүлэмжийн аж ахуйг эрхлэхэд болохгүй юм байхгүй. Эрхэллээ гэхэд бүтээгдэхүүнээ УБ хот руу тээвэрлэхэд бэрхшээл учирна. Хөрөнгө оруулалт их шаардагддаг юм. Бидний хувьд тавьж байгаа гол зорилт бол үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг бүрэн ашиглаж, 100 хувьд хүргэх. Түүхий эдээ эцсийн бүтээгдэхүүн болгож гаргах зорилготой. Энэ зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө тэргүүн ээлжинд анхаарч ажиллах болно. Халтар арвайн хувьд Алаг-Эрдэнэ сортын бага зэргийн үрийн нөөц бий. Гар аргаар арвайн гурилыг бага хэмжээгээр хийж байна.

Н.Ерөөгэрэл- За өөр асуулт тавих хүн байхгүй байна. Одоо санал хураах ажилдаа орё. Та бүхэнд саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар Тооллогын комиссоос мэдээлэл өгнө. Тооллогын комисс ажилдаа орно уу?

Тооллогын комиссын дарга Ц.Наран-Учрал санал хураалтын талаарх Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Санал хураалтад 13 724 873 ш хувьцаатай 38 хувьцаа эзэмшигч оролцон хэлэлцсэн 3 асуудлыг 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаа өгөөгүй хурлын дундуур гарч явсан байв.

\Тооллогын комиссын тогтоолыг материалд хавсаргав\

Н.Ерөөгэрэл- ХЭХ-аар хэлэлцсэн асуудал бүрээр гарах тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Тогтоолоо батлах уу? Санал нэгтэй баталлаа.

Шийдвэрлэсэн нь: ХЭХ-аас гарах тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 13 цаг 35 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Хурлын дарга

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Н.Ерөөгэрэл

С.Оюунгэрэл